

БАТЛАВ. МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

А.ЗАНГАД

АУДИТИН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Аудитын нэр

Газрын тосны тухай хуулийн хэрэгжилт, хуулийн төлбөр тооцоо

2. Аудитын код

ҮАГ-НАГ-/2014/05-НАГ

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны даргын 2014 оны “Аудитын сэдэв батлах” тухай З дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудитораас 2014 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

4. Аудитын зорилт

Газрын тосны тухай хуулийн хэрэгжилт, төлбөр, тооцооны байдлыг шалган дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэнэ. Үүнд:

1. Газрын тосны тухай хуулийн хэрэгжилтийн байдал;
2. Газрын тосны тухай хуулийн төлбөр тооцооны байдал /БНМАУ-ын газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журмын дагуу/
3. Газрын тосны тухай хуулийн төлбөр тооцооны байдал / Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгаар/

5. Аудитын хамрах хүрээ

Аудитад батлагдсан хуваарийн дагуу Уул уурхайн яам, Газрын тосны газрын гүйцэтгэсэн ажлын тайлан, ГЕГ-ын статистик мэдээлэл болон бусад холбогдох материалд тулгуурлан гүйцэтгэнэ.

Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж 2014 оны 7 дугаар сарын 1-нээс эхлэн хэрэгжиж эхэлсэн тул өмнөх хуулийн төлбөр тооцооны байдлыг 2014 оны эхний хагас жилээр, одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн төлбөр тооцооны байдлыг 2014 оны сүүлийн хагас жилээр тус тус хамруулна.

6. Үндсэн мэдээлэл

Газрын тосны үйл ажиллагаатай холбогдсон харилцааг 1991 оны “Газрын тосны тухай” хууль, “БНМАУ-ын Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журам”-

аар зохицуулж ирсэн бөгөөд УИХ-аас тус хуулийн шинэчилсэн найруулгыг 2014 оны 7 дугаар сарын 1-ний өдөр баталж, мөрдүүлэхээр болсон байна.

Одоогийн байдлаар БХГ-т 21 талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж байгаагаас 3 талбайд газрын тосны нөөц тогтоогдсон ба 18 талбайд газрын тосны хайгуулын ажлууд хийгдэж байна.

Газрын тосны олборлолт, экспортын үйл ажиллагааг БНХАУ-ын Петрочайна Дачин Тамсаг, Доншен газрын тос (Монгол) ХХК-иуд БХГ-т Тосон-Уул XIX, Тамсаг-XXI болон 1997 оны гэрээт талбайнуудад явуулж байна.

1990-2009 онд манай улсын газрын тосны салбарт хийгдсэн хөрөнгө оруулалтын хэмжээ 1.1 тэрбум ам. долларт хүрч, Тамсагийн сав газрын Тосон-Уулын орд, Дорноговийн сав газрын Зүүнбаян, Цагаан-Элсний орд газраас туршилтын журмаар 5.25 сая баррель буюу 711.3 мян.тонн түүхий тос олборлон БНХАУ-д экспортолж, улсын нэгдсэн болон орон нутгийн төсөвт 85.3 тэрбум төгрөгийн орлого оруулжээ.

Тамсагийн сав газарт газрын тосны үйл ажиллагаа явуулж буй Петрочайна Дачин Тамсаг ХХК, Тосон-Уулын ордоос олборлож байгаа тосны хэмжээг нэмэгдүүлж 2010 онд 250.0 мянган тонн буюу 1.8 сая баррель, цаашлаад 2015 онд 925 мян.тонн буюу 6.9 сая баррельд хүргэх урьдчилсан тооцоог ирүүлээд байна.

Эрсдэлийн үнэлгээ

Төлөвлөлтийн үе шатны ажлын явцад цуглуулж судалсан баримт, материал, хамрах хүрээ, нөхцөл байдалд хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн хийх аудитын эрсдэлийн өрөнхий үнэлгээг “Дунд” гэж үзлээ.

7. Аудитын арга зүй

Аудитын явцад Төрийн хяналт шалгалтын стандартын хүрээнд гүйцэтгэлийн болон зохион байгуулалтын аудитын арга зүйг ашиглан, аудитын хөтөлбөрийн дагуу холбогдох горимоор нотлох зүйл цуглуулж, дүн шинжилгээ хийн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

8. Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглана. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Газрын тосны тухай хууль
- БНМАУ-ын газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журам
- Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга
- Гаалийн тарифын тухай хууль
- Бүтээгдэхүүн хуваах гэрээ
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
- УИХ, ЗГ-ын холбогдох тогтоол, дүрэм, журам

9. Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын дарга Б.Алтанзул хянан удирдаж, аудитын менежер З.Ариунзаяа, ахлах аудитор Л.Хонгорзул, аудитор Г.Ганбаатар, шинжээч Л.Нямтөмөр нар ажиллана. +2

10. Аудитын хугацаа

Аудитыг 2014 оны 10 дугаар сарын 20-нд эхэлж, 2015 оны 2 дугаар сарын 1-нд дуусгаж, 3 дугаар сарын 1-ний дотор УИХ-д танилцуулна.

11. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл

Аудитын тайлан нь ерөнхий зүйл, аудитын дүн, судалгааны дүгнэлт, холбогдох байгууллагын санал, аудитын зөвлөмж болон хавсралт хэсгүүдээс бүрдэнэ.

Аудитын тайлангийн төслийг Монгол Улсын Ерөнхий аудитор болон УИХ-д танилцуулж, баталгаажуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

12. Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц

- а. Боловсон хүчин: ҮАГ - 75 өдөр * 3 хүн - 225 хүн/өдөр
- б. Санхүүгийн нөөц: Цалингийн зардал: 7,875.0 мянган төгрөг
- в. Үйл ажиллагааны зардал: 2,550.0 мянган төгрөг
- г. Аудитын нийт зардал: 10,425.0 мянган төгрөг
- д. Техник хэрэгсэл: Зөөврийн компьютер, дектафон, скайнэр, фото аппарат болон бусад техник хэрэгсэл

Аудитын төлөвлөгөөг

Хянаж зөвшөөрсөн:

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ДЭД ДАРГА

Б.БАТТУЯА

Боловсруулсан:

НИЙЦЛИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА

Б.АЛТАНЗУЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

З.АРИУНЗАЯА

АХЛАХ АУДИТОР

Л.ХОНГОРЗУЛ

АУДИТОР

Г.ГАНБААТАР

ШИНЖЭЭЧ

Л.НЯМТӨМӨР